



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 19 өдөр

Дугаар А/118

Шивээговь сум

Мал угаалгын ажил зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.6, 21 дүгээр зүйлийн 21.3.1, 31 дүгээр зүйлийн 31.4, аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/18 дугаар тушаал “Технологит ажил үйлчилгээ зохион байгуулах тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Малыг шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний хүрээнд хийгдэх мал угаалгын ажлыг 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2021 оны 08 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл технологит хугацаанд нь зохион байгуулсугай.

2. Мал угаалгын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Сугармаа (Сумын Засаг даргын орлогч дарга)

Нарийн бичгийн дарга: Ш.Буяннэмэх (Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч)

Гишүүд: С.Отгонбаатар (2 дугаар багийн Засаг дарга)

Н.Амаржаргал (1 дүгээр багийн Засаг дарга)

А.Цэрэндолгор (“Хийморь Алтай групп” Мал эмнэлгийн нэгжийн эмч)

3. Угаалганд хамрагдах малын тоог хавсралтаар баталсугай.

4. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангаж ажиллан технологийн мөрдөлтөнд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулж, ажлын тайлан гаргаж, дүгнэлт хийн хариуцан ажиллахыг Мал эмнэлэг тасгийн улсын байцаагч (Ш.Буяннэмэх)-д, мал угаалгын товыг мал, амьтан өмчлөгчдөд зарлан мэдээлж, малчдын малыг бүрэн хамруулахыг 1 дүгээр багийн Засаг дарга (Н.Амаржаргал), 2 дугаар багийн Засаг дарга (С.Отгонбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

5. Мал угаалгын ажлыг чанартай, стандартын дагуу хийж дуусгахыг Мал эмнэлгийн нэгжийн эмч (А.Цэрэндолгор)-т даалгасугай.


6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Отгонжаргал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2001 оны 07-р
сарын 19-ны өдрийн дугаар
захирамжийн хавсралт-1



УГААЛГАНД ХАМРУУЛАХ МАЛЫН ТОО

№	Сумын нэр	Хамрагдах малын тоо			
		Үхэр	Хонь	Ямаа	Бүгд
1	Шивээговь	1000	26476	27591	55067